



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2016 оны 9 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт
Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

1. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуулийн 138.4-т заасныг үндэслэн Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоотой зөвшилцсөний үндсэн дээр Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

Засгийн газрын
төлөөлөл:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
- Сангийн дэд сайд;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны
Төрийн нарийн бичгийн дарга;
- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн
дарга.

Ажил олгогчийн
төлөөлөл:

- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны
дэд ерөнхийлөгч;
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн
танхимын ерөнхийлөгч;
- Монголын авто замчдын холбооны ерөнхийлөгч;
- Монголын арьс, ширний үйлдвэрлэлийн холбооны
гүйцэтгэх захирал;
- Монголын барилгын хөгжлийн нэгдсэн төвийн
ерөнхийлөгч;
- “Монголын Экспресс” ХХК-ийн захирал.

Ажилтны
төлөөлөл:

- Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны
ерөнхийлөгч;

- Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга;
- Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга;
- Монголын үйлдвэрлэл үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга;
- Монголын эрчим хүч, геологи, уул уурхай үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга;
- Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Ерөнхий сайдын 2015 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 205 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ